



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 528

Улаанбаатар хот

**“Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын
бүтцийн схем, албан тушаалын жагсаалтыг
батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схемийг 1 дүгээр хавсралт, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 72 (далан хоёр) байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 269 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн
...дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**“ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ТӨВ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ**



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн
5-дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**“ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ТӨВ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН
ЖАГСААЛТ, ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
2	Ерөнхий менежер	1
	Санхүүгийн алба	9
3	Албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	1
4	Тооцооны нягтлан бодогч	3
5	Нярав	4
6	Хангамж хариуцсан мэргэжилтэн	1
	Захиргаа маркетингийн алба	9
7	Албаны дарга	1
8	Менежер	3
9	Хуулийн зөвлөх	1
10	Хүний нөөцийн ажилтан	1
11	Архив бичиг хэргийн ажилтан	1
12	IT инженер	1
13	Маркетингийн ажилтан	1
	Сургалтын алба	12
14	Албаны дарга	1
15	Тир зохион байгуулагч	1
16	Заал зохион байгуулагч	2
17	Дасгалжуулагч	8
	Техникийн алба	12
18	Ерөнхий инженер	1
19	Дулаан хангамжийн инженер	1
20	Сантехникийн инженер	1
21	ХАБЭА ажилтан	1
22	Барилга байгууламж, тоног төхөөрөмж, ашиглалт хариуцсан инженер	1
23	Дуу, гэрэлтүүлэгийн техникч	1
24	Цахилгааны техникч	3
25	Сантехникч	3
	Нийтлэг үйлчилгээний алба	28
26	Нийтлэг үйлчилгээний ахлах зохион байгуулагч	1
27	Мужаан	1
28	Ахлах тогооч	2
29	Туслах тогооч	4
30	Зөөгч	2
31	Бэлтгэгч, угаагч	2
32	Манаач	2
33	Харуул	4
34	үйлчлэгч	8
35	Жолооч	2
	НИЙТ ОРОН ТОО	72